

Тайлагнах хугацаа:		2022.01.01-нээс 2022.12.31
Тайлан гаргасан:		ТУЗ-ийн НБД Б.Нямбаяр
Хийж гүйцэтгэсэн ажлын чиг үүргүүд	1	Компанийн засаглалын талаарх бодлого, дүрэм журмыг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах
		Компанийн засаглалын кодексийн зарчмыг хэрэгжүүлэх үүднээс ТУЗ-ийн дэргэд “Ёс зүйн хороо”-г шинээр үүсгэн байгуулж, компанийн нийт ажилчид, удирдах албан тушаалтан, эрх бүхий албан тушаалтан нийтээр дагаж мөрдөх ”Ёс зүйн дүрэм”-ийг боловсруулан батлуулсан. Ёс зүйн дүрмийн зарчим, дүрмийн хэрэгжилтийн талаар ТУЗ-ийн дарга Л.Эрхэмбаяр, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Хүний нөөцийн менежерүүдийн хамтаар компанийн нийт ажилтнуудад танилцуулга хийж, мэдээллээр ханган ажилласан. Мөн компанийн засаглалын кодексийн өөрийн үнэлгээг хийж 62 оноо буюу 83%-ийн үнэлгээтэй тайлагнаж, холбогдох зохицуулагч байгууллагуудад илгээсэн. Уг үнэлгээг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга А.Бакей болон компанийн дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтан Ж.Уянга нарын хамт хийж гүйцэтгэлгээ. Компанийн засаглалын кодексн үнэлгээний тайланг ТУЗ-ийн гишүүдэд танилцуулж, цаашид кодексн хэрэгжилтийг хангахад шаардлагатай асуудлуудыг шийдвэрлүүлэхээр ТУЗ-ийн үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөнд оруулан ажиллахаар тогтлоо. Баримт: – www.tumenshuvuut.mn сайт, Хөрөнгө оруулагчдад цэс-Компанийн засаглалын кодексн үнэлгээний тайлан хэсгээс
	2	Компанийн засаглалыг сайжруулах санал боловсруулсан байдал
		Компанийн засаглалын кодексн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУЗ-ийн 2022 оны 11-р сарын 23-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн батлуулж ажиллалаа. 1. Цалин урамшууллын хорооны бүтцэд өөрчлөлт оруулах, 2. Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын жагсаалтыг батлуулах Үүнд: - Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд - Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга - Гүйцэтгэх захирал - Дэд захирал - Ерөнхий нягтлан бодогч - Албаны дарга нар - Үйлдвэрийн дарга нар - Охин компанийн захирал - Охин компанийн дэд захирал Баримт: www.tumenshuvuut.mn сайт, Хөрөнгө оруулагчдад цэс – Тузын хуралдааны мэдээлэл хэсгээс
3	ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, ажиллах	
	ТУЗ нь 2022 онд нийт 6 удаа буюу цахимаар 2 удаа, биечлэн 2 удаа, эчнээ хэлбэрээр 2 удаа тус тус хуралдаж, нийт 17 асуудалд үнэлэлт, дүгнэлт өгч, 15 шийдвэр гаргасан бөгөөд эдгээр хурлуудын бэлтгэл зохион байгуулалт, хурлаар хэлэлцэх асуудлын	

	<p>танилцуулга бэлтгэх, хурлаас гарах шийдвэрийн төслийг боловсруулах, ТУЗ-ийн гишүүдэд хэлэлцэх асуудлын тухай мэдээлэл, баримт материалыг цаг тухай бүрт нь хариуцлагатайгаар хүргэх, мэдээлэх үүргээ хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>Баримт: www.tumenshuvuut.mn сайт, Хөрөнгө оруулагчдад цэс – Тузын хуралдааны мэдээлэл хэсгээс</p>
4	<p>ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах</p> <p>2022 онд Нэр дэвшүүлэх хороо: 3 удаа хурал зохион байгуулж, хэлэлцсэн асуудалтай холбоотой 6 асуудлыг шийдвэрлэж, 5 дүгнэлт гаргасан.</p> <p>Цалин урамшууллын хороо: бүрэн эрхийнхээ хугацаанд 1 удаа хурал зохион байгуулж, “Түмэн шувуут” ХК-ийн гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, уг тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах асуудлыг хэлэлцэн, тус бүр 2 дүгнэлт гаргасан.</p> <p>Аудитын хороо: Эрх үүргийнхээ хүрээнд нийт 3 удаа хуралдаж, 5 асуудал шийдвэрлэсэн.</p> <p>Ёс зүйн хороо: 1 удаа тус тус хуралдсан бөгөөд хороодын хурлуудын бэлтгэл ажлыг хангах, гишүүдэд зар хүргэх, аудитын байгууллагын сонгон шалгаруулалтыг сонгох зар түгээх, хурлын материал танилцуулга бэлтгэх, хороодын хурлаас гарах дүгнэлтийн төслийг боловсруулан хороодын хурлыг амжилттай зохион байгуулж ажиллалаа.</p>
5	<p>ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад оролцогч талуудын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хувьцаа эзэмшигчид, олон нийтэд хүргэх</p> <p>“Түмэн шувуут” ХК-ийн үйл ажиллагаа болон санхүүгийн мэдээлэл, Төлөөлөн Удирдах Зөвлөл, түүний дэргэдэх хороодын бүтэц зохион байгуулалт, тэдгээрийн шийдвэр, батлагдсан дүрэм журам, шинэчлэлт, өөрчлөлт, нэмэлт мэдээллийг өөрийн www.tumenshuvuut.mn цахим хаяг, Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаст цаг тухай бүрт нь оруулж ажилласан.</p> <p>Мөн “Түмэн шувуут” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04 сарын 23-ний өдөр болсон ба хурлыг “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу амжилттай зохион байгуулж, хурлын талаархи мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон өөрийн цахим хуудсаараа дамжуулан мэдээллэсэн.</p>
6	<p>Компанийн комплайнсын ажилтны чиг үүргийн биелэлтийг хангах, хяналтыг хэрэгжүүлэх</p> <p>Монголын хөрөнгийн биржээс зохион байгуулсан “Комплайнсын хяналтын заавар”-ын танилцуулга сургалтанд хамрагдсан, Сургалтанд заасан мэдлэг мэдээлэл, танилцуулгыг ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдэд тайлагнасан.</p>
7	<p>Охин компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүргийг хавсран гүйцэтгэсэн байдал</p> <p>“Түмэн шувуут” ХК-ийн охин компани болох “Усжуулах” ХКомпани нь 2022 оны 04 сарын 29-ний өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдсан ба ХЭЭХурлыг “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу зохион байгуулж, хурлаар хэлэлцэх асуудал болон хурлаас гарах шийдвэрийн төслийг боловсруулан хэлэлцүүлж, батлуулсан.</p>
8	<p>Хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талаас ТУЗ-д ирүүлсэн санал, гомдол, хүсэлтийг шийдвэрлэхэд оролцсон байдал</p> <p>Хувьцаа эзэмшигчдийн зүгээс ямар нэгэн санал гомдол, хүсэлт, өргөдөл зэргийг www.facebook.com/tumenshuvuut албан ёсны цахим хуудсын чат хэсгээр хүлээн авдаг бөгөөд ирсэн асуудал бүрт холбогдох ажилтан шуурхай хариу өгч, бүртгэл хөтлөн ажиллаж байна. Мөн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь утсаар ирсэн санал гомдол,</p>

	хүсэлтэд шууд хариулт өгч ажиллада. Харилцагч, хэрэглэгч, хувьцаа эзэмшигчдээс 2021 онд 49, 2022 онд 23 санал гомдол бүртгэгдэж, холбогдох эрх бүхий албан тушаалтнуудад хүргэгдэж, шийдвэрлэх арга хэмжээнүүдийг авч ажиллажээ. Харин компанийн нийт ажилтнуудын хувьд бичгээр болон өөрсдийн өдөр тутамдаа байнга ашигладаг "timely" системээрээ дамжуулан ирүүлсэн санал бодол, өргөдөл хүсэлтэд хуулийн хугацаанд нь тодорхой хариу өгч ажилласан.
9	Албан хэрэг хөтлөлтийн бүртгэл мэдээлэл
	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргын ТУЗ-ийн хурал зарлан хуралдуулах тухай нийт 6 албан бичиг, ТУЗ-ийн хурлаас гарсан нийт 15 шийдвэр, ХЭЭХ-ийн 3 тогтоол, хурлын дэлгэрэнгүй тэмдэглэл-1, ТУЗ-ийн дэргэдэх хороодын 4 дүгнэлт, 4 хурлын тэмдэглэл, ТУЗ-ийн хурлын 4 дэлгэрэнгүй тэмдэглэл, 2 эчнээ санал хураалтын тэмдэглэлийг тус бүрт нь бүртгэл үүсгэн хөтөлж тэмдэглэсэн.
10	Сургалт, хөгжилд хамрагдан мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байдал
	Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Монголын хөрөнгийн биржээс хамтран зохион байгуулсан ТУЗ-ийн нарийн бичгийн даргын мэргэшүүлэх сертификаттай сургалтанд хамрагдаж мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн.